

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

Улирал тутмын цахим сонин

Дугаар №1

2020 оны 4 дүгээр улирал

Онцлох үйл явдлууд:

- Боловсролын хүрээлэнгийн захирал П. Лхагвасүрэнгийн арилцлага
- Төслийн үйл явцын тоон үзүүлэлтээс
- Жендер, жендэрийн тэгш эрхийн асуудлаар багц мэдээлэл
- Цаг үеийн онцлох мэдээ мэдээлэл
- Тогтвортой хөгжлийн сайн туршлагаас
- Орон нутгийн сониноос

Гарчиг

ТХБ-Зочин	2
ТХБ-Үйл явц	4
ТХБ-Нэг сэдвээр	6
ТХБ-Сайн туршлага	8
ТХБ-Мэдээ	10
ТХБ-Зөвлөмж	12

МЭНДЧИЛГЭЭ

Монголчууд бид эрт дээр үеэс байгалийн нөөц баялгийг зохистой ашиглаж, байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн нүүдлийн соёл, уламжлалтай билээ. Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд хүн ам өсч, улс орны эдийн засаг хөгжихийн хэрээр хотжилт, байгаль орчны бохирдол, доройтол нэмэгдэх, байгалийн нөөцийг зохисгүй ашиглах болсноор байгалийн онгон дагшин байдал, экосистемийн тэнцвэрт байдал алдагдаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Швейцарын хөгжлийн агентлаг хамтран тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан бидний ирээдүй хойч үе болсон хүүхэд, залууст байгаль орчинд ээлтэй амьдралын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор “Тогтвортой хөгжлийн боловсрол” төсөл хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаар төслийн зорилтот бүлэг болох багш, сурган хүмүүжүүлэгч, сурагч, олон нийтэд мэдээ, мэдээлэл түгээх зорилгоор цахим сонин эрхлэн гаргаж байна.

Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан үндэсний хэмжээнд гаргах уг цахим сонин нь хоёр сар тутам та бүхэнд тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих чиглэлээр олон улс болон дотоодод хэрэгжүүлж байгаа шинэ санаачилга,



сайн туршлага, мөн төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг хүргэх болно. Шинэ оны босгон дээр цахим сонингийн анхны дугаар та бүхний гарт хүрч байгаад баяртай байна.

Уншигч танд шинэ оны мэнд хүргэж аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ГАНБОЛД

“Тогтвортой хөгжлийн боловсрол II”
төслийн удирдах хорооны дарга

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ БИД ДЭМЖИЖ ТҮГЭЭНЭ

Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан Монгол Улсын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгоход дэмжлэг үзүүлэх нь “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн зорилго билээ. Энэхүү зорилго, үйл ажиллагааны

зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Тогтвортой хөгжлийн боловсрол, Ногоон хөгжлийн талаарх тогтвортой хөгжлийн боловсрол олгогчид, мөн олон нийтэд мэдээ мэдээлэл, мэдлэг түгээх нь манай сонины үндсэн зорилго юм. Цахим сонин бие даасан редакцын зөвлөлтэй байх бөгөөд тус зөвлөл нь

сонины нийтлэлийн бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт, агуулгатай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Уншигч танд сонины нийтлэлтэй холбоотой санал хүсэлт, мэдээ мэдээлэл байх аваас сонины редакцад хандаарай.



Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газрын дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн түшиц байгууллага нь БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн юм. Энэ хүрээлэн дээр боловсрол, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, тэдгээрийн харьяа агентлагууд, төрийн бус байгууллагаас бүрдсэн төслийн “Техникийн зөвлөн зохицуулах үндэсний баг” ажиллаж байна. “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн бодлого, үйл ажиллагааг тодруулж Боловсролын хүрээлэнгийн захирал, боловсрол судлалын доктор П.Лхагвасүрэнтэй ярилцлаа.

Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) гэж чухам юуг хэлж байна гэдгээс ярилцлагаа эхэлье.

Хүмүүс бид байгаль орчин, эх дэлхийтэйгээ, өргөн утгаараа байгаль эхтэйгээ хэр зэрэг зохицож, ажиллаж амьдарч байна, оршин тогтох, амьдрах эх үндэс болсон эх дэлхийгээ яаж хайрлан хамгаалж, хязгаарлагдмал баялаг нөөцүүдээ хэрхэн үр дүнтэй ашиглаж байна вэ гэдэг нь хүн төрөлхтний тулгамдсан асуудал болсоор байна.

Энэ асуудлыг ногоон хөгжлийн буюу тогтвортой хөгжлийн бодлогоор дамжуулж ирээдүй хойч үедээ суулгаж өгөх нь тогтвортой хөгжлийн боловсролын суурь асуудал.

Дэлхий нийтийн өмнө тулгарсан энэ

хөтөлбөр, агуулга, суралцахуйн зорилтуудаар дамжуулж хүүхэд залуучуудад хүргэж, танин мэдүүлж, хэрэгжүүлэхээс гадна үндэсний том цөм баг байгуулахаар БШУЯ, БОАЖЯ, түүний харьяа олон байгууллага, их дээд сургуулиудын төлөөллөөс бүрдсэн төслийн зөвлөн зохицуулах багийг Боловсролын хүрээлэнг түшиглэн ажиллуулж байна.

“Тогтвортой хөгжлийн боловсрол I төсөл амжилттай хэрэгжсэн үндэс, туршлага дээр хоёр дахь төслийг мөн амжилттай хэрэгжүүлж байгааг онцолъё.

Тогтвортой хөгжлийн буюу ногоон хөгжлийн боловсролыг олон нийтэд түгээх, хүргэх үндэсний бүтэц бүрэлдэхүүн, бааз суурь “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн үр дүнд бүрэлдэн тогтох юм байна гэж

П.ЛХАГВАСҮРЭН:

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛГЫГ
БОЛОВСРОЛООР
ДАМЖУУЛАН ОЛГОХ НЬ
ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ



асуудлыг НҮБ-ээс тогтвортой хөгжлийн бодлого болгон хүн төрөлхтний өмнө дэвшүүлэн гаргаж ирснээр дэлхийн улс орнууд анхааралдаа авсан.

Улмаар дэлхий нийтэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудаа тогтвортой хөгжлийн өнцгөөр харж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын өнцгөөс шийдэх, байгаль дэлхийгээ ирээдүй хойч үедээ зөв хүлээлгэж өгөх нь чухал асуудал болж дэвшигдэж байгаа юм.

НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2030” хөтөлбөрийн хүрээнд Монгол улс “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрөө баталж, урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д ногоон хөгжлийн бодлогоо суулгаж, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр боловсролын асуудлыг авч үзэх үзэл баримтлалаар “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА), Боловсрол шинжлэх ухааны яам (БШУЯ) хооронд 2020 онд байгуулсан гэрээний хүрээнд Боловсролын хүрээлэн энэ төслийн менежментийг хийхээр шалгарч, ажлаа амжилттай гүйцэтгэж байна. Энэ хүрээнд тогтвортой хөгжлийн боловсролыг Монгол улсын боловсролд суулгаж шингээж өгөх, сургалтын

ойлголоо?

“Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн нэг зорилго нь энэ. Монгол улс тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн боловсролын чиглэлээр үндэсний том баг, бүтэц бүрэлдэхүүнтэй, түүгээр дамжуулж нүүдэлчин Монголчуудын байгаль эх дэлхийгээ хамгаалж ирсэн уламжлал, үзэл баримтлалыг улам бэхжүүлэн хөгжүүлэх том бааз суурь үүснэ гэж үзэх ёстой юм.

Монгол улсын Засгийн газар төсөл хэрэгжүүлэх нэгжийг тусад нь биш Боловсролын хүрээлэнг түшиглэн байгуулсан шалтгаан нөхцөлийг та тодорхойлбол?

Үүнийг хоёр талаас нь харж үзэж болно. Нэгд олон улсын томоохон төслүүд тусдаа нэгж бүтэцтэй байж хэрэгждэг. Өмнө нь ч “Тогтвортой хөгжлийн боловсрол I” төсөл ингэж хэрэгжиж байсан. Үүнд ажлын байрнаас эхлээд эдийн засгийн, хүний нөөцийн гээд олон асуудал тулгардаг.

Мөн төсөл дуусахад тухайн ажил нь эзгүйрч хоцрох тал бий. Тэгвэл “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн онцлог нь үндэсний мэргэжлийн байгууллагыг сонгож, түүн дээр түшиглэн бодлогоо хэрэгжүүлснээр дээрх асуудлаас сэргийлж байгаа юм. Боловсролын хүрээлэн 1956 онд байгуулагдсан 60 гаруй жилийн баялаг түүхтэй Монгол улсын боловсролын

толгой цөм байгууллага. Боловсролын бүх асуудлыг судалгааны үндсэн дээр дэвшүүлж гаргадаг, хэрэгжүүлдэг, туршдаг цөм байгууллагынхаа хувьд их дээд болоод ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролд сургалтын хөтөлбөр, агуулга, стандарт суралцахуйн зорилтуудаар дамжуулан тогтвортой хөгжлийн боловсролыг шингээж өгөх маш том боломж үүсэж байгаа юм. Энэ нь чухал ач холбогдол. Тиймээс Боловсролын хүрээлэнг сонгосон нь санамсаргүй хэрэг биш гэдэг нь ойлгомжтой. Гол нь манай Засгийн газар, Швейцарын хөгжлийн агентлаг зөв байгууллагаа сонгосон гэж хэлмээр байна.

Эцсийн бүлэгт ямарваа нэгэн ажлын үр дүн нь тухайн ажлыг зохион байгуулж, ачааллыг үүрч байгаа хүмүүсийн оюуны, мэргэжлийн, сэтгэлийн хүчин чадлаас шалтгаалдаг. Манай төсөл амжилттай хэрэгжиж байгаа үндэс суурь нь эдгээр нөхцөлийг хангасан хүний нөөцтэй баг ажиллаж байгаатай холбоотой. XXI зууны хүн төрөлхтөнд, тэр дундаа Монголчууд бидэнд тулгамдаж байгаа хамтарч ажиллах, багаар ажиллах, харилцан бие биеэ ойлголцох том харилцаа энэ төсөл дээр амжилттай хэрэгжиж байгаа юм. Манай хүрээлэн БОАЖЯ, БШУЯ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Байгаль орчны мэдээлэл сургалтын төв ТББ зэрэг тухайн төслийг хэрэгжүүлдэг багийн гишүүн бүх байгууллагатайгаа нягт хамтран ажиллаж, 2020 онд дэвшүүлсэн зорилтоо амжилттай зохион байгуулж байгааг хэлэхэд таатай байна.

Төслийн зөвлөн зохицуулах үндэсний баг нь Тогтвортой хөгжлийн боловсролыг бүхэл бүтэн систем болгохын тухайд институтчилэх, түншлэлийг бий болгох асуудлуудыг өдөр бүрийн үйл ажиллагаандаа шингэн хэрэгжүүлж байна. Мөн үйл ажиллагаагаа цааш тасралтгүй үргэлжлүүлж амжилттай авч явах бодлогоо ч өнөөдрийн үйл ажиллагаатайгаа уялдуулж байгаа юм. Ер нь боловсрол олгох гэдэг нь хүүхдийг эхийн сүүгээр нь амлуулж байгаатай адил. Тиймээс ч ногоон хөгжил, тогтвортой хөгжлийг эдийн засаг, нийгэм, байгаль орчны тал дээр тогтвортой оршин тогтноулах зорилтыг боловсролоор дамжуулах нь хамгийн оновчтой, хамгийн үр дүнтэй шийдэл юм.

Танд баярлалаа.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II” ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ЗӨВЛӨН ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ БАГ (ТЗЗҮБ)



Техникийн зөвлөн зохицуулах үндэсний баг (ТЗЗҮБ) нь тогтвортой хөгжлийн боловсролын тулгуур багана болох экологи, эдийн засаг, нийгэм-соёлын хүрээг хамарсан олон салбарын мэргэжилтнүүдээс бүрддэг.

ТЗЗҮБ-ийн үйл ажиллагааны ерөнхий чиглэл:

ТХБ-ын талаарх ойлголт, мэдлэгийг сум дүүрэг, орон нутаг, үндэсний түвшинд гүнзгийрүүлэх зорилгоор зорилтод бүлгийн болон ажлын байран дахь сургалтуудыг зохион байгуулж, үндэсний, орон нутгийн зөвлөн зохицуулах багийн гишүүдийг чадавхжуулах,

ТХБ II төслийн зорилтыг хангах, үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн багш нар, бусад хэрэгжүүлэгчдэд зориулсан сургалтын материал, арга аргачлал боловсруулах, хэвлэх, түгээх

ТХ-ийн төлөө “сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага”-ыг сургуулийн менежментэд нэвтрүүлэх, “Ногоон оффисийн менежмент ба соёл”-ыг үндэсний болон орон нутгийн байгууллагуудад нэвтрүүлэх ажилд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх, зөвлөн туслах,

ТХБ II төслийн үзэл санаа, үйл явц, үр дүнг олон нийтэд болон олон улсад таниулан сурталчлах зэрэг ажлыг эрхэлдэг.

ТЗЗҮБ-ийн ёс зүйн дүрмээс онцолбол:

ТЗЗҮБ-ийн гишүүн бүр баримталдаг ёс зүйн дүрэмтэй. Дүрмийн үндсэн зарчим нь эрх тэгш оролцох, хүн бүрийн дуу хоолойг сонсох, бусдын ялгаатай, өөр байдал, үзэл хандлагыг хүлээн авах чадвартай байх, хүндэтгэх, хамтын шийдвэр нь ил тод, алагчлалгүй байх, аливаад бүтээлчээр хариуцлагатай, ёс зүйтэй хандахад оршдог.

ТХБ нь гурван хэмжээст арга тул бүх агуулга нь энэхүү шинж чанарыг дэмжиж, экологи, нийгэм-соёл, эдийн засгийн асуудлыг багтаасан байх ёстойг ямагт харгалзан аливаад тогтолцоогоор нь хандах нь ТЗЗҮБ-ийн баримтлах зарчмуудын нэг юм.

ТЗЗҮБ-ийн гишүүдийн хамтын бүтээлч шийдвэр нь Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой шийдвэр гаргахад нөлөөлөх болно гэдгийг бид ямагт харгалзан үзэх учиртай.

ТЗЗҮБ-ийн хамтын ажиллагааны хүрээ:

ТЗЗҮБ нь ШХА, Боловсролын хүрээлэн болон БШУЯ, БОАЖЯ, МХЕГ, боловсролын болон байгаль орчны салбарын холбогдох агентлагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, ТББ-ууд, хувь судлаач шинжээчид, төсөл хэрэгжүүлэх аймаг, дүүрэг, сумдын төрийн захиргааны болон мэргэжил, арга зүйн байгууллагууд, төсөлд хамрагдсан сургууль, эцэг эх, иргэд олон нийтгүй хамтын ажиллагаатай.

Гишүүн байгууллагууд	ТЗЗҮБ-ын гишүүд
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Т.Төрбадрах <i>НХБТГ-ын Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн</i>
Боловсрол, шинжлэх ухааны яам	А.Цолмон <i>Бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч</i>
	Б. Дуламсүрэн <i>ЕБ-ийн чанарын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн</i>
Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	Н. Мөнхбаяр <i>Суралцагчийн хөгжлийн албаны дарга</i>
	Ч.Гажиддулам <i>ТНУ-ны багийн хөгжил хариуцсан арга зүйч</i>
Байгаль орчны мэдээлэл сургалтын төв	Л. Тэмүүжин <i>УЗ-ын гишүүн, Техникийн ахлах зөвлөх</i>
	Г. Батцэцэг <i>Хөтөлбөрийн менежер</i>
Боловсролын үнэлгээний төв	Б. Батсүх <i>Үнэлгээ хөгжүүлэлтийн хэлтэс, нийгмийн ухааны хичээлийн судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн</i>
	Р.Ундрахбаяр <i>Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн</i>
Боловсролын хүрээлэн	А.Энхтогтох <i>Боловсролын хөтөлбөрийн судалгааны секторын эрхлэгч</i>
	Ж.Дэнсмаа <i>Математик, мэдээлэл зүйн сурах бичгийн судалгаа хариуцсан ЭША</i>
Насан туршийн боловсролын үндэсний төв	Л. Болортунгалаг <i>Захирал</i>
	Б. Лут- Очир <i>Мэдээлэл технологийн мэргэжилтэн</i>
Монгол Улсын боловсролын их сургууль	Я. Шийлэгмаа <i>Эрдэм шинжилгээ, инновацын албаны дарга</i>
	Д. Үүрийнуяа <i>Гадаад харилцааны албаны дарга</i>
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	М. Нямсүрэн <i>Боловсрол, соёлын хяналтын хэлтсийн дарга</i>
	Д. Өнөржаргал <i>Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч</i>
Хэвлэл мэдээллийн байгууллага	Б. Билгүүнхангал <i>МУОНТВ-ийн «Өглөө» хөтөлбөрийн дарга</i>
	Д.Даваадулам <i>ТХТ-ийн «Амгалан дэлхий» ТББ-ын тэргүүн, сэтгүүлч</i>
Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв	Д. Шижирболд <i>Судалгаа, мэдээлэл, сургалтын албаны дарга</i>
	Ц. Ичинхорлоо <i>Сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн</i>

“Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн хувьд орон нутагт хэрэгжүүлэгч байгууллагаар “Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” ТББ шалгаран ажиллаж байна.



Тус байгууллага нь 2003 онд байгуулагдсан, 17 дахь жилдээ тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Захиргаа, санхүү болон Сургалтын алба гэсэн бүтэцтэй.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

Ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр сургалт, судалгаа хийх

Монгол Улсад ОУ-ын Эко-сургууль, Ойн тухай суралцахуй, Байгаль орчны залуу сурвалжлагч, Цэнхэр туг, Ногоон түлхүүр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

Байгаль орчны нөхөн сэргээлт, орчны тохижилтын үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгөх


Байгаль орчны мэдээлэл сургалтын төв нь Архангай, Хөвсгөл, Хэнтий, Ховд, Булган,



Орхон болон Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргээс сонгогдсон загвар сургуулиуд, мөн төслийн Техникийн зөвлөн зохицуулах орон нутгийн багтай хамтрах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах юм.

Тус байгууллага нь ОУ-ын болон үндэсний 20 гаруй эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн зөвлөх багтай.

Байгаль орчин, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр 10 гаруй судалгаа, 30 гаруй ном, гарын авлага, бүтээлүүдийг дангаар болон хамтран боловсруулжээ.



ТӨСЛИЙН ҮР ДҮН (2020/IV УЛИРАЛ)

БОЛОВСРУУЛСАН БИЧИГ БАРИМТ	СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ	БҮТЭЭЛ, НОМ ГАРЫН АВЛАГА	СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА
Төсөлд хамрагдсан нийслэл, аймгийн 30 сургуульд зориулсан СБААХ-ын сургуулийн өөрийн үнэлгээний хяналтын хуудсыг боловсруулсан.	Сургуулийн менежментэд СБААХ-ыг нэвтрүүлэх сургуулийн өөрийн үнэлгээний хяналтын хуудасны мэдээлэл, өгөгдлийг бүртгэх, хянах, боловсруулах, тайлагнах арга хэрэгсэл болох нийт 25 эксел хуудас бүхий EXCEL платформыг боловсруулсан.	ТХ-ийн төлөөх сургуулийн өөрийн үнэлгээний хяналтын хуудас болон СБААХ-ын 5 айн хүрээнд гарын авлагын багц болох 10 номыг бүтээл болгон, хэвлэхэд давхардсан тоогоор нийт 258 хүн оролцон боловсруулж түгээлтийг орон нутаг, төслийн хүрээнд хамтраж ажиллаж буй байгууллагуудад түгээгээд байна.	ТЗЗОНБ-ийн гишүүдийг чадавхжуулах Сургуулийн менежментэд СБААХ-ыг нэвтрүүлэх сургалтад 6 аймаг 2 дүүргийн холбогдох мэргэжлийн байгууллагын нийт 42 төлөөлөл оролцсон.
Төслийн хүрээнд хэрэгжүүлэх “Ногоон оффис”-ын хяналтын хуудсыг боловсруулсан.	Загвар сургуулийн 900 сургагч багш нараас “Google form” ашиглан сургалтын чанарын үнэлгээний 2 удаагийн тестийн үнэлгээг авч нэгтгэн цаашдын үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.	Зайны онлайн сургалтад ашиглах Moodle сургалтын системийг бэлтгэсэн бөгөөд орон нутгийн ТЗЗБ-ийн 120, ЕБ-ын сургуулийн 900 оролцогчид нэвтрэх боломжтой юм. Энэхүү систем рүү аймаг тус бүр 30 хүнтэй 30 анги тус бүр өөрийн нэвтрэх нэр, нууц үгээрээ орж сургалтын хэрэгцээт мэдээллээ авах бүрэн бололцоотой орчинг үүсгэсэн.	Төсөлд хамрагдсан нийслэл, орон нутгийн сургуулиуд Сургуулийн өөрийн үнэлгээний арга зүйн танхимаар зохион байгуулагдсан сургалтад 30 сургуулийн нийт 572 хүн оролцсон.
Төсөлд хамрагдсан 6 аймаг 2 дүүргийн засаг дарга нартай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.	ТХ-ийн төлөөх загвар сургуулиуд СБААХ-ын сургуулийн өөрийн үнэлгээний хяналтын хуудсаар дамжуулан нийт 11000 орчим зорилтот бүлгийн хүмүүсийг хамруулан, үр дүнг нэгтгэн боловсруулж, өнөөгийн түвшингээ тодорхойлоод байна.	ТХБ-ыг дэмжих жижиг төслийг боловсруулах, шалгаруулах багц материалыг боловсруулан сургуулиудад хүргүүлсэн.	ТЗЗОНБ-ийн гишүүд болох 107 хүн оролцсон нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулсан.
БСУГ, БОАЖГ, БОМСТ, загвар сургууль хооронд хамтын ажиллагааны 4 талт гэрээг ЕБ-ын 30 сургуультай байгуулсан.			Нийт 29 сургуулийн 731 сургагч багш нарт зориулсан MS.OJ.1.b. кодтой нэг өдрийн сургалтыг 2020 оны 10-р сарын 05-18-ны өдрүүдэд Улаанбаатар, Архангай, Булган, Орхон, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудад тус тус зохион байгуулсан.
Төсөлд хамрагдсан ЕБ-ын сургуулиудын төслийн хугацаанд хэрэгжүүлэх жижиг төслийн саналыг боловсруулан ЗДТГ, БОМСТ болон сургууль хоорондын хамтарсан 3 талт гэрээг хийж байна.			ТЗЗОНБ-ийн гишүүдтэй хамтран зохион байгуулсан “Төлөвлөлтийн арга зүй ба жижиг төслийн арга зүй” сургалтад 29 сургуулийн 731 сургагч багш нар хамрагдсан.
			ТЗЗҮБ-тай хамтран жижиг төслийн шалгуур үзүүлэлт, менежментийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан.
			ЕБ-ын сургуулийн гүйцэтгэлийн төлөвлөлтийн арга зүйн сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг ЗГ-ын Хэрэг Эрхлэх Газар, Удирдлагын Академитай хамтран үе шаттайгаар зохион байгуулж байна.

“Тогтвортой хөгжлийн боловсрол II” төсөлд хамрагдсан нийслэл, орон нутгийн загвар сургуулиудын хамтын ажиллагаа, тоон үзүүлэлт

Булган аймаг

Эрдмийн Өргөө цогцолбор сургууль
Хишиг-Өндөр сумын ЕБ-ын сургууль
Могод сумын ЕБ-ын сургууль
Хялганат сумын ЕБ-ын сургууль

Орхон аймаг


ЕБ-ын 15 дугаар сургууль
ЕБ-ын 4 дүгээр сургууль
ЕБ-ын 5 дугаар сургууль
ЕБ-ын 14 дүгээр сургууль

Хэнтий аймаг

Тэмүүжин цогцолбор сургууль
Галшар сумын ЕБ-ын сургууль
Хан-Хэнтий цогцолбор сургууль
Баян-Адарга сумын ЕБ-ын сургууль
Дадал сумын ЕБ-ын сургууль

Улаанбаатар хот

БГД-ийн Эрдмийн өргөө цогцолбор сургууль
СХД-ийн 122 дугаар ахлах сургууль
ЕБ-ын лаборатори 28 дугаар сургууль
Шинэ эхлэл олон улсын лаборатори сургууль




Сурагч 41315

Багш 1922

Ажилчид 812

Удирдлага 107



Хөвсгөл аймаг

Рашаант сумын ЕБ-ын сургууль
ЕБ-ын "Авьяас" сургууль
Дэлгэрмөрөн цогцолбор сургууль
Цэцэрлэг сумын ЕБ-ын сургууль
Хатгал тосгоны ЕБ-ын сургууль

Ховд аймаг

ЕБ-ын лаборатори 1 дүгээр сургууль
ЕБ-ын 2 дугаар сургууль
Буянт сумын ЕБ-ын сургууль
Мөнххайрхан сумын ЕБ-ын сургууль

Архангай аймаг

ЕБ-ын 2 дугаар сургууль
ЕБ-ын 3 дугаар сургууль
Тариат сумын ЕБ-ын сургууль
Батцэнгэл сумын ЕБ-ын сургууль

Сургуулийн өөрийн үнэлгээний арга зүйн сургалт

572

Сурагч багшийн сургалт MS.OJ.1

Сургуулийн менежментэд СБААХ-ыг нэвтрүүлэх

42

ТЗЗОНБ-ын сургалт ST.TT.1

Төлөвлөлтийн арга зүй ба жижиг төслийн менежмент

731

Сурагч багшийн сургалт MS.OJ.2

Сургуулийн менежментэд СБААХ-ыг нэвтрүүлэх

107

ТЗЗОНБ-ын сургалт ST.TT.2

Жижиг төслийн хэрэгжилтийн менежментийг дэмжих

95

Сурагч багшийн сургалт MS.OJ.3


2021 оны гүйцэтгэлийн төлөвлөлтөд СБААХ-ыг тусгах

168

Сурагч багшийн сургалт MS.OJ.4

Сургалтанд хамрагдсан хүний тоо


(сургалт, хувь)



MS.OJ.1 (33.35%) MS.OJ.2 (42.62%) MS.OJ.3 (5.54%) MS.OJ.4 (9.8%) ST.TT.1 (2.45%) ST.TT.2 (6.24%)




Оролцогчдын хүйсийн харьцаа



Эмэгтэй (76.16%) Эрэгтэй (23.84%)




Зорилтот бүлгийн төлөөллийн харьцаа




Сургуулийн төлөөлөл (85.16%) ТЗЗОНБ-ын гишүүн (14.84%)

#1

Сургалтын үнэлгээ, үр дүн




Сургуулийн төлөөлөл зорилтот бүлгээр




Удирдлага (26.13%) Багш (21.75%) Ажилтан (13.78%) Сурагч (10.48%) Эцэг, эх (10.41%) Олон нийт (17.44%)

ТЗЗОНБ-ын төлөөлөл зорилтот бүлгээр



ЗДТГ, НБХ (24%) БСУГ, НТБТ (36.8%) БОАЖГ, ТХГНЗ (18.4%) МХГ (11.2%) ХГБЗГ (4.8%) Бусад (4.8%)

Зорилтот бүлгийн оролцоо орон нутгаар



Орхон (14.64%) Хэнтий (16.07%) Ховд (16.42%) Улаанбаатар (9.13%) Архангай (12.28%) Булган (13.72%) Хөвсгөл (17.74%)

ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН АСУУДАЛД

Тогтвортой хөгжлийн боловсролын нэг тулгуур багана нь жендер, жендерийн тэгш байдал юм. Тиймээс ч дэлхийн улс орнууд жендерийн эрх тэгш байдлын төлөө бүх нийтээрээ нэгэн бодлого, зорилгын дор дуу хоолой, хүчээ нэгтгэдэг. Түүний нэг нь Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын аян. Энэ жил дэлхийн 190 гаруй орон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянаа "Өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт ЯГ ОДОО жендэрт суурилсан хүчирхийллийг цэглэе" уриа дор 11 сарын 25-наас 12 сарын 10-ны өдрүүдэд өрнүүлээ. Манай улс энэ аяныг төр, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагуудтай хамтран 23 дахь жилдээ зохион байгуулсан юм.



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ
16 ХОНОГИЙН АЯН

Жендерийн тэгш байдлыг хангахад саад болж байгаа хэвмэл ойлголтыг өөрчлөх, үйл явцыг манлайлах гэдэг зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор удирдах албан тушаалтан болон албан хаагч нэг бүрийн оролцоог хангах, үүн дээр жендерийн мэдрэмжтэй төсөв хийх, холбогдох албан хаагч, багш, сурган хүмүүжүүлэгч нартаа энэ чиглэлийн мэдээ мэдээллийг тасралтгүй өгөх, тодорхой сургалт зохион байгуулах чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.



Л.Цэдэвсүрэн
Боловсрол, шинжлэх ухааны сайд




ХЭҮК жижиг дунд үйлдвэрүүдэд явуулсан судалгаагаар дөрвөн эмэгтэй тутмын нэг нь ажлын байрны бэлгийн дарамтад өртөж байна.

А.Ариунзаяа
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

Та жендерийн асуудал алхам тутамд тулгарч байдаг гэж бодож байвал жендерийн мэдрэмж, мэдлэгийн суурь танд үүсэж байна гэсэн үг

Т.Амгалан
Жендерийн үндэсний хорооны зөвлөх,



Орчин үед жинхэнэ эр хүн гэж ялгаатай талуудыг хүлээн зөвшөөрдөг, аливаад эрх тэгш ханддаг, ялгаварлан гадуурхдаггүй, нөөцийг тэгш, хүртээмжтэй хуваарилдаг, хөгжил, боломжийг олгодог, олон ургалч байдлыг эрхэмлэдэг, харилцаанд ул суурьтай ханддаг хүнийг хэлэх болов уу.

Н.Батзориг
Социологич

Уншигч та цахим сонины “Ярилцаж байна” индэрт тавтай морил. Бид Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаярыг урьж, ярилцлаа.

Т.ЭНХБАЯР

ХҮЧИРХИЙЛЛИЙН
ХОХИРОГЧДЫН 90-
ЭЭС ДЭЭШ ХУВЬ НЬ
ОХИД
ЭМЭГТЭЙЧҮҮД
БАЙДАГ



Саяхан дэлхийн 190 гаруй орон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянаа өндөрлөлөө. Дэлхий нийтээрээ нэгддэг, нэг дуу хоолойгоор илэрхийлдэг энэ ажлын үр дүнг та хэрхэн тодорхойлох вэ?

Юуны өмнө Та бүхний эрхлэн хийж байгаа энэхүү ажлын анхны зочноор уригдаж байгаадаа баяртай байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аяны зорилго нь охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа аливаа хүчирхийллийн эсрэг олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, тэднийг татан оролцуулах явдал юм. Аян хийхээр л хүчирхийлэл байхгүй болох уу гэсэн асуулт ч нийгмийн сүлжээнд байсан. Тийм биш л дээ. Хоёрхон зорилго байгаа. Мэдээлэлтэй болгох, аянд олон нийтийг татан оролцуулах гэсэн. Аянаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэснээр таны гэрт, ажлын байранд хүчирхийлэл үйлдэгдэхгүй байсан ч хөршийн чинь гэрт хүчирхийлэл гарч байвал та мэдээлэх, ажлын байранд чинь бэлгийн дарамт байвал мэдээлж тэмцэхийг уриалж, ийм хандлага, мэдлэгтэй болгохыг л зорьж байгаа юм.

Байгалийн гамшиг, цар тахал, дайн тулаан гээд давагдашгүй хүчин зүйлийн үед хүчирхийлэлд охид, эмэгтэйчүүд хамгийн ихээр өртөж, хохирдог. Ийм учраас цар тахалтай тэмцэж байгаа энэ цаг үед жендэрт суурилсан хүчирхийлэл өсөж байгаа талаар дэлхийн олон улс мэдээлж байна.

Учир нь хатуу хөл хорионы үед гэр бүл дотроо хүчирхийлэлд өртөж байгаа хүн гараад хэн нэгэнд мэдээлэх, хамгаалах байранд очих боломж нь хязгаарлагдмал болдог тул хүчирхийлэл илүү далд хэлбэрт шилждэг байна.

Иймээс хүчирхийллийн эсрэг дуу хоолойг өндөрт гаргаж,

“Хүн бүрт тэгш, хүртээмжтэй байдлыг сурталчлах, ялгаварлан гадуурхахгүй байх арга хэлбэрийг хөгжүүлэх нь тогтвортой хөгжил, хүртээмжтэй эдийн засгийн хөгжилд хүрэх, ядуурлыг устгах, энх тайвныг бий болгох гол түлхүүр гэдэгт бид итгэлтэй байна. Хүйсийн тэгш бус байдал нь хүмүүсийн сэтгэлгээ, хандлага, зан үйлд нь шингэсэн хэвээр байх тохиодолд Жендэрт суурилсан хүчирхийлэл нь бидний хэнд нь ч, надад, танд болон таны хүүхдүүдэд, хэнтэй ч, хаана ч тохиолдож болно.



Стефани Бурри
Швейцарын хөгжлийн агентлагийн дарга



Охидоо хамгаалах хамгийн үр дүнтэй арга бол хөвгүүддээ сайн хүмүүжил, боловсрол олгох юм

Б.Идэр-Од

мэдээлдэг болгох, хэдийгээр өндөржүүлсэн бэлэн байдлын үед ч гэсэн хохирогчийг хамгаалах төвүүдийг ажиллуулдаг байх зэргээр дэлхийн улсууд уриалдаг байна. Энэ жилийн аяныг дэлхий нийтээрээ Ковид-19 цар тахлын үед цахим хэлбэрээр өрнүүллээ. Төр, төрийн бус, хувийн хэвшлийн болоод олон улсын байгууллагууд хамтран цахим орчинд хүчирхийллийг таслан зогсоох хэрвээ энэ үйлдэл гарч байгаа бол яг одоо мэдээлэх, оролцохыг олон нийтэд урилсан.

Таны ажиглалтаар цар тахлын үед гарч байгаа шийдвэрүүд жендерийн хэр мэдрэмжтэй байна вэ?

Гамшгийн үед гарч байгаа шийдвэрүүдээс жендэртэй холбоотой хэд хэдэн асуудал харагдаж байна. Тухайлбал, жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдэхгүй, хүчирхийллийн дуудлага, мэдээлэл бага байна гэдгийг хүчирхийлэл гарахгүй байна гэж ойлгох нь өрөөсгөл. Тиймээс үнэлгээг байнга хийж байх ёстой. Яагаад гэвэл дээр хэлсэнчлэн илүү далд хэлбэр рүү шилжиж байх магадлалтай.

Түүнчлэн хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлж байгаа төвүүдэд хүрч ажиллах, мэдээж цар тахлын улмаас нэмэлт зардлууд үүсэж байгааг анхаарахгүй орхиж болохгүй. Харин олон улсын байгууллагуудын тусламж дэмжлэг энэ чиглэлд хүрч байгаад талархалтай байна. Дараагийн нэг асуудал нь цар тахлын үед нийтийн халуун усыг хаасан байгаа.

Хэдийгээр халдвар тараах өндөр эрсдэлтэй гэж үнэлж байгаа хэдий ч дэлхий нийтийн жишгийг харахад ийм тохиолдолд эмэгтэйчүүдийн ариун цэврийн асуудал хөндөгддөг. Нийтийн халуун ус хэрэглэдэг бүлгийн ариун цэврийн асуудал гэсэн үг. Охид, эмэгтэйчүүдийн хэрэгцээ өөр шүү дээ. Тэр байтугай хөвгүүд, эрчүүдийн ариун цэврийг ч хүртэл ярих ёстой.

Жендерийн тэгш эрхийн үндсэн зарчмыг энгийнээр хэлбэл?

Хуульд жендерийн тэгш эрхийг хангах чиглэлээр таван зарчим бий. Анхаарч үзвэл бүгдээрээ их чухал. Хуульд байгаа тодорхойлолтыг сийрүүлээд хэлбэл, жендерийн тэгш эрхийн зарчим гэдэг бол нийгмийн бүхий л харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил тэнцүү оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломжийг ойлгоно.

Гэтэл хүн амын 50 гаруй хувь болсон эмэгтэйчүүд нийгмийн амьдралд тэгш эрхтэй, эн тэнцүү оролцож байгаа гэж харвал яагаад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэхгүй байна вэ, яагаад хүчирхийлэлд 90 орчим хувь нь эмэгтэйчүүд өртөөд байна, яагаад эмэгтэйчүүдийн



А.Хонгорзул:
“Хөөрхөн зүрх” ТББ-ын тэргүүн,
сэтгэл зүйч

Хөвгүүд эрчүүд өөрийн сэтгэл хөдлөл, мэдрэмжээ мэдрэх, илэрхийлэх бүрэн эрхтэй ч нийгэм шоглож доромжилж байгаа нь олон хор уршигтай. Тиймээс бид өөрсдийн хэвшмэл ойлголтоосоо бага ч болов хөндийрч сэтгэлээ мэдэрдэг, илэрхийлдэг хөвгүүд, эрчүүдийг дэмжье.

хөдөлмөрийн оролцоо буураад байна вэ. Мэдээж хүүхдээ төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэх нь зүйтэй боловч энэ нь хөдөлмөрлөх эрхийг нь хязгаарлаж болохгүй шүү дээ, харин ясли, цэцэрлэгийн хүртээмжтэй байдал, хүүхдээ харангаа ажил хийх боломж, жендерийн мэдрэмжтэй ажлын байрыг хөгжүүлэх гээд хүн амаа өсгөх бодлогыг гэр бүлийн эдийн засаг улмаар улс орны эдийн засагт хувь нэмэр оруулахаар зохицуулалт хийж болно. Түүнчлэн хөвгүүд, эрэгтэйчүүдийнхээ хөгжлийн асуудалд анхаарах цаг аль хэдийн ирсэн. Нэн ялангуяа эрэгтэйчүүдийнхээ эрүүл мэндэд.

Жендэр нь тогтвортой хөгжлийн боловсролын тулгуур нэг багана. Чухам яагаад гэж асуувал?

Тогтвортой хөгжлийн амин сүнс бол хэнийг ч орхигдуулахгүй хөгжих юм. Өөрөөр хэлбэл эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, залуучууд, охид хөвгүүд гээд хүн амын бүлгүүдийг орхигдуулахгүй хөгжлийг хамтдаа бүтээнэ. Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 5-р зорилго нь жендерийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд хүчирхэгжүүлэх, эрх мэдэл хуваарилалтыг эн тэнцүү олгох, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох гээд тодорхой зорилтууд орсон. Түүнчлэн бусад бүхий л зорилго, зорилтууд жендерийн мэдрэмжтэй байхаар тодорхойлогдсон байдаг.

Танд баярлалаа.



ЖИЖИГ ТӨСЛИЙН ТОМ ҮР ДҮН

Хөвгүүд өөрсдийнх нь санаачлагаар эхэлж, багш, эцэг эхчүүд, төрийн болон төрийн бус байгууллага гээд олон талын оролцоотой өрнөж, бусдад үлгэр өгөх үр дүнг харуулсан “Хөвгүүдийг чуулган” “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслөөс эхтэй юм.

Хөвгүүд өөрсдийгөө хөгжүүлэхэд хэрхэн анхаарч байна, чөлөөт цагаа үр дүнтэй ашиглаж чадаж байна уу, эсвэл..., аминчхан нууцаа хэнтэй хуваалцаж, мэдээллийг хаанаас авдаг вэ, хөвгүүд багш, эцэг эхчүүдтэйгээ нээлттэй байж чаддаг уу?

Ийм байдлаар хөвгүүдэд ярилцаж хэлэлцэх, зөвлөгөө авах, туршлага солилцох, шийдэл гаргах асуудал олон бий. Яг л энэ сэдвээр Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хөвгүүд 11 сарын 30-ны өдөр чууллаа.

Одоо ч хөвгүүд чуулганахаа талаар сонин сайхан яриа хөөрөө, ажил хэрэг, санал сэтгэгдлээ өрнүүлсээр байна. “Хөвгүүдийн манлайлал” чуулганд хөвгүүд өөрсдөө санал бодлоо илэрхийлэхээс гадна багш, мэргэжилтнүүд, эцэг эхийн төлөөлөл сонирхол татах судалгаа, жишээтэй, санаа сэдэл өгөх илтгэл тавьж, сурагчидтай ярилцсан байна.

Тухайлбал “Эрэгтэйчүүдийн амьдралд эзлэх байр суурь, зорилго”, “Монгол цэргийн бахархал”, “Биеэ засаад гэрээ зас”, “Хөвгүүдийн нууц”, “Хөвгүүдээс хөвгүүдэд” зэрэг сэдвээр ХИС, Ховд аймгийн ГБХЗХГ, Цэргийн штаб, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллага, эцэг эхийн зөвлөл мэдээлэл зөвлөгөө өгч, ажил хэрэгч яриа өрнүүлсэн юм.

Мөн чуулганыг санаачлагч 2-р сургуулийн 11 ангийн сурагч Э.Отгон-сайханы илтгэл үеийнхнийхээ анхаарлыг татаж, санаа сэдэл өгөв. Сургуулийн эрэгтэй багш нар дуу хуураа өргөж, хөгжөөнт тоглоом тоглуулсан нь чуулганд оролцогчдыг хөгжөөж, уур амьсгалыг улам ч халуун дулаан, чөлөөтэй болгосныг оролцогчид нь онцоллоо.

Ингэж сурч боловсрох оролцоо хандлага, манлайллаа сайжруулах гарц боломжоо ярилцсан хөвгүүд “Зөв цагийн зөв хүн байцгаая” уриалгыг үеийнхэндээ дэвшүүлсэн байна.



Тогтвортой хөгжлийн боловсрол II төслөөс эхтэй хөвгүүдийн чуулган

“Тогтвортой хөгжил боловсрол II” төсөлд хамрагдсан Ховд аймгийн ерөнхий боловсролын 2-р сургууль сурагч, багш, эцэг эхчүүдийнхээ дунд өөрийн үнэлгээний судалгаа явуулахад “дэлхийн иргэншилд хөл нийлүүлэх зорилго чиглэлтэй сургалт, хөтөлбөр хэрэгтэй байгаа”г оролцогчид нь мэдэгдээд үүнд хөвгүүдийн оролцоо, манлайлал сул байна гэсэн асуудлыг тавьжээ.

Ингээд Тогтвортой хөгжлийн боловсрол II төслийг хэрэгжүүлэгч «Байгаль орчны мэдээлэл сургалтын төв» ТББ-аас зарласан 100 000 төгрөгийн төсөвтэй жижиг төслийн


уралдаанд тэд “Хөвгүүдийн манлайлал”-ыг хэлэлцэх чуулганы төслөө өгсөн нь шалгарсан байна.

Хөвгүүдийн оролцоо хандлагыг сайжруулах, зөв төлөвшилийг бий болгох зорилготой тус чуулганг цаашид сургуулийн төдийгүй сум, аймгийн “брэнд” үйл ажиллагаа болгон тогтмол зохион байгуулах саналыг олон нийтээс 2-р сургуулийн хамт олонд гаргасан байгаа юм.



**ХОВД АЙМГИЙН ГБХЗХГ-ЫН
МЭРГЭЖИЛТЭН Б.НЭМЭХБУЯН:**

Би “Хөвгүүдийн манлайлал” чуулганаар KFC компанийг үүсгэн байгуулагчийн түүхээс хөвгүүдэд ярьсан. Заавал их дээд сургуульд сурч байж амжилт гаргана гэх биш хийж чадах, хүсэл сонирхолтой ажлаа мэргэжил болговол аз жаргалтай амьдарна гэдгийг ойлгуулахыг хичээсэн. Үүнээс эхлээд зөвхөн хөвгүүдэд тулгардаг асуудлууд ч олон байдаг нь энэ чуулганаас харагдаж байлаа. Миний хувьд нийт оролцогчдын 20-30 хувьд нь сэдэл тэмүүлэл өгч, нөлөөлсөн болов уу гэж бодож байна.




**2-Р СУРГУУЛИЙН НИЙГМИЙН
АЖИЛТАН Ц.СҮРЭНХОРЛОО:**

Тогтвортой хөгжлийн боловсрол II /ТХБ II/ төслийн үр дүнд манай сурагчдын экологийн боловсрол дээшилж, багш, эцэг эх, сурагчдын хамтын ажиллагаа, түншлэл сайжирч байна. Жишээ нь ТХБ II төслийн сургалтын үр дүнд багш, эцэг эх, сурагчид хамтарч сургуулийн орчинд тулгамдсан асуудлаа өөрсдөө тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга замыг хайж жижиг төсөл бичсэн. Энэ төслийн нэг нь 11 сард амжилттай зохион байгуулсан “Хөвгүүдийн манлайлал” чуулган юм

Энэ чуулганд манай сургуулийн дунд ангийн бүх хөвгүүд идэвхтэй оролцлоо. Учир нь төслийн зөвлөмж, арга зүйн хүрээнд эрсдэлийг урьдчилан тооцоход оролцоон дээр асуудал гарч болзошгүй байсан. Тиймээс ирц, оролцоог багш нарын анги даалтын урамшуулалтай уялдуулж өгсөн нь 100 хувь үр дүнгээ өгсөн.

Мөн манай сургуульд тулгардаг бас нэг асуудал нь ус, хог хаягдалтай холбоотой. Сургуулийн жорлонгийн усны татуурга эвдэрснээс байнга гоождог усыг тооцоход Ховд аймгийн Жаргалант сумын нийт усны алдагдлын 6 хувийг эзэлж байсан. Дээр нь багш, сурагчдын ар гэр уух усаа голдуу хуванцар саванд агуулдаг гэх зэргээр усны хэрэглээтэй холбоотой асуудлыг өөрсдийнхөө өдөр тутмын амьдралтай холбож шинжиж судалж мэдэж авлаа. Ингэснээр шийдэх аргаа хүртэл өөрсдөө тодорхойлж, хэрэгжүүлж чадаж байна. Үр ашиггүй урсаж байгаа усыг харахаар бүгд л сэтгэл өвддөг болчихдог юм байна.

Манай сургуульд голдуу Ховд аймгийн Жаргалант сумын ногоочдын хүүхдүүд суралцдаг. Тиймээс бид ТХБ II төслийн хүрээнд хүлэмж байгуулж, багш, эцэг эхчүүд, сурагчид хамтран өргөст хэмх, улаан лооль, хулуу тарьж, өнгөрсөн намар ургацаа хураасан. Энэ ажил манай сургуулийн түншлэл, сурагчдын экологийн боловсролд бодитой хувь оруулж байна.



**ХОВД АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2-Р ДУНД
СУРГУУЛИЙН 11 АНГИЙН
СУРАГЧ Э.ДАНИЕЛ:**

Бид “Хөвгүүдийн манлайлал” чуулганаараа өөрсдөдөө тулгардаг асуудлаа чөлөөтэй ярьж, мэргэжлийн ах эгч нараас зөвлөгөө, мэдээлэл авч чадсан. Хөвгүүд бид ч өөрсдөө манлайлагч байх ёстой гэдэг дээр санал нэгдсэн. Сургуульд ахлах ангийнхан дүү нартаа том зан гаргах, дүү нар ах нараасаа цэрвэх, айх хандлага байдаг. Гэтэл энэ чуулганы дараа дунд ангийн дүү нар сургууль дээр бидэнтэй мэндэлдэг, юмаа асуудаг болсон. Бидэнд их хэрэгтэй уулзалт болсон.



ХАЯГДАЛ ЦААСАА ТУШААЖ ХЭВШЛЭЭ

Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт /БМДИ/ хаягдал цаас дахин боловсруулах үйлдвэрүүдэд үдээсгүй, скочгүй, шохойгүй хаягдал цаасаа тушааж хэвшжээ.

Тэд энэ удаа хаягдал цаас боловсруулагч “Түвшин Сайхан” үйлдвэртэй хамтрахаар хаягдлаа цуглуулж байгаа тухай мэдээллээ. Тус үйлдвэр 1кг цагаан цаасыг 50 төгрөг, бичгийн цаас, бор хатуу хайрцаг, хуучин номыг 20 төгрөгөөр тус тус авдаг. Эдгээр цаасыг дахин боловсруулж ариутгаад өндөгний бор сав, хайрцаг зэрэг сав боодол зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд гаргадаг байх юм. Харин гялгар бүрээстэй сонин



сэтгүүлийг дахин боловсруулахад өндөр хүчин чадалтай техник шаарддаг учраас авч эхлээгүй байна. БМДИ байгууллага, иргэдийг хаягдал цаасаа ялган ангилж, үйлдвэрүүдэд тушаахыг уриалж байгаа

юм. Олон нийт энэ тууршлагаас суралцан ашигласан бичгийн цаас, хуучин ном, сонин, бараа бүтээгдэхүүний баглаа боодол, тавилгын хайрцаг зэргээ шууд хаялгүй, дахин боловсруулдаг, худалдан авдаг цэгүүдэд тушаах боломжтой. Энэ бол ой мод, уснаас эхлээд байгалийн нөөц баялгаа хамгаалж, гэрэл цахилгаан зэрэг зардлаа хэмнэхэд оруулж буй тогтвортой хөгжлийн төлөөх үйл хэрэг юм.

Ийм байдлаар ТХБ II төслийн үр дүнд байгаль орчин, нийгэмд ээлтэй, туршлага болохуйц үйл ажиллагаанууд өрнөж, үр дүнгээ өгч байна.

ХАЯГДАЛ БАТЕРЕЙГ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГСЛЭЭР СОЛЬДОГ

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын Физикийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч Н.Сайнбаяр хаягдал батареи цуглуулах хайрцаг ажиллуулдаг. Цугласан батареигаа “Компьютер ланд” худалдааны төвд тушааж, хариуд нь физикийн хичээлийн зарим хэрэглэгдэхүүнээ авдаг байна. Тэрээр Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооноос хэрэгжүүлдэг “Ногоон паспорт” аянд хамрагдсанаар энэ ажлаа эхэлжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Нийслэлийн Боловсролын газар, Байгаль орчны газар, Монголын хог хаягдлыг дахин боловсруулах


үндэсний холбооноос хамтран хэрэгжүүлж буй тус аянд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хамрагдаад хоёр жил болж байгаа нь энэ. Аяны хүрээнд тус институтын багш нар батареин хор уршгаас эхлээд хаягдал батареи цуглуулах, ялгах туршлага мэдээллээ солилцож, хаягдал зай цуглуулж хэвшээд байна. Хаягдал зай хураагуур нь гаднын нөлөөнд өртөн задралд орж хөрс, ус агаарыг бохирдуулснаар хүн, амьтанд шууд, мөн бохирдсон хөрс, ус, ургамлаар дамжин дам нөлөө үзүүлдэг байна. Бидний хайхрамжгүйгээр хог хэмээн хаядаг хуруу зай гэхэд л кадми, хар тугалга, мөнгөн ус, лити зэрэг хортой металл өөртөө агуулдаг учраас байгальд төдийгүй хүний биед сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал нэг ширхэг

хуруу зай гэхэд л 8000 л усыг хордуулдаг байх юм. Иймд цэнэггүй болсон зайг жирийн хог хаягдлаас ялгаж, зориулалтын цэгүүдэд тушааж хэвшвэл хаягдал зайтай холбоотой зөв шийдэл гарах хугацааг түргэсгэж, нэгдсэн зохицуулалттай болоход чухал түлхэц болно.



СААРАЛ УСЫГ БОХИР ЗАЙЛУУЛАХАД АШИГЛАЖ БАЙНА

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын төслийн дэмжлэгтэйгээр саарал усаа жорлонгийн ус хураагуурт дахин ашиглаж байна. Орон сууцанд амьдардаг нэг хүн өдөрт дунджаар 34.4 литр усыг жорлонгийн усны зориулалтаар урсгадаг гэсэн тоо бий. Энэ цэвэр усыг саарал усаар сольж, ашиглавал ойролцоогоор өдөрт 3.8 л цэвэр ус хэмнэх боломжтой гэж тооцоолжээ. Цэвэр усны



нөөц багасч, зарим улс оронд ундны усны хомсдол үүсч буй энэ үед хаягдал ус, борооны усыг дахин

ашиглах эрэл хайгуул улам ч эрчимжиж байна. Тухайлбал Европын өмнөд хэсгийн зарим улсад ундны усны хомсдол үүсээд байгаа тул цэвэр усыг хэмнэх, ундны усны өөр эх үүсвэр хайх шаардлага тулгарчээ. Дэлхийн гадаргын 70 хувийг усан бүрхүүл эзэлдэг ч яг үнэндээ нийт усны 2.5-хан хувь нь л цэнгэг ус байдаг. Тэгвэл үүний ердөө гуравны нэг нь л бид хэрэглэж болохуйц хэлбэрээр оршиж, үлдсэн нь мөсөн зооринд

МАЛЧДАД РАДИОГООР, СУРАГЧДАД ТАНХИМААР ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХИЧЭЭЛ ОРЛОО

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв таван жилийнхээ ойгоор тогтвортой хөгжил, усны үнэ цэнийн талаар ойлголт, мэдээлэл өгөх сургалтыг Дундговь аймгийн Мандалговь хотод зохион байгууллаа. Тус сургалтад "Мандал" цогцолбор сургуулийн ахлах ангийн 40 гаруй сурагч хамрагдаж, тогтвортой хөгжлийн гурван багана болох нийгэм, эдийн засаг, байгаль орчны

харилцан хамаарлын талаар ярилцаж, усны үнэ цэнэ, усаа хайрлан хамгаалах талаар сургуулийн орчин тойрондоо хийж, хэрэгжүүлж болох шинэ санал санаачлага, үйл ажиллагааны талаар харилцан ярилцлаа. Мөн сургалтын үеэр тус аймгийн Эрдэнэдалай сумын 420 гаруй малчин айл өрхөд тогтвортой хөгжил, ногоон хөгжил, ногоон худалдан авалт болон байгаль орчны илтгэл хичээлүүдийг радио станцаар дамжуулан хүргэлээ.



“АГААРЫН БОХИРДЛООС ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛЖ ЧАДНА” ЭСЭЭ УРАЛДААНД 700 СУРАГЧ ОРОЛЦОВ



Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв болон НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Та агаарын бохирдлоос өөрийгөө хамгаалж чадна” эсээ бичлэгийн уралдааныг Монгол орны нийт ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 10 дугаар

сарын 26-аас 12 дугаар сарын 15-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Эсээ бичлэг нь хүүхэд залуучуудад тогтвортой хөгжлийн үзэл санаа, үнэт зүйлийг бий болгох замаар залуусын дуу хоолойг нийгэмд хүргэх, агаар орчны бохирдлоос өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг өгөхөд чиглэгджээ. Уралдаанд 700 гаруй хүүхэд оролцсоноос 1-р байранд Орхон аймгийн Баян-Өндөр сумын 14-р сургуулийн сурагч Э.Сувданчимэг, 2-р байранд Завхан аймгийн Их-Уул сумын сургуулийн сурагч П.Мөнгөнзул тус тус шалгарсан бол “Шинэ Монгол” сургуулийн 12-р ангийн сурагч Г.Лхагвасүрэн 3-р байр эзэлжээ. Шилдэг 10 хүүхэд мөнгөн шагнал, БОАЖЯ-ны “ногоон паспорт” аяны өргөмжлөл

гардууллаа. Сурагч П.Мөнгөнзул “Монгол хүн аргал таанын тансаг үнэр үнэрлэж өссөн билээ. Гэвч сүүлийн жилүүдэд нүүрсний утаа үнэрлэж аргалын цэнхэр утаа бяцхан мөрөөдөл болох нь ихсэв” гэж бичсэн бол сурагч Г.Лхагвасүрэн “Өглөө эртлэн босоход хажуугийн байрнаас цааших байр харагдахгүй манан будан хөшиглөсөн мэт униартах, хоолой зуран бяцхан уушгийг минь хоргох утааг би яаж арилгах тухай их боддог” гэж агаарын бохирдлын асуудлыг хөндсөн байна.

МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ QR КОДООР ТАНЬЖ ЭХЭЛЛЭЭ

“Тоглож байгаа бөмбөгөө, өмсөж байгаа бээлийгээ аль аймгийн хэн гэдэг малчны ямар арьсаар эсвэл сарлагийн хөвөрөөр хийснийг QR код уншуулаад л мэдчихдэг болжээ. Ингээд нэг малчдын хөдөлмөрийг үнэлж, малын ашиг шимийг технологийн дэвшилтэй холбоод өгчихвөл ч долларын зам ойрхон доо” гэж Шууд.mn сайтын сэтгүүлч саяхан нүүр номондоо бичсэн байв. Энэ бол Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт малын эрүүл мэнд” төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа технологийн код, чанар, түүнийг эргэн мөшгих “Хариуцлагатай нүүдэлчид” цахим систем юм. “Хариуцлагатай нүүдэлчид” системийг монгол малчдын зүй зохистой дадлыг гадаад дотоодын зах зээл, хэрэглэгчдэд сурталчлан таниулах, үнэлэх, хөхүүлэн дэмжих зорилгоор 2019 оноос нэвтрүүлж эхэлжээ.




Дэлхийн зах зээлд хэрэглэгчид байгальд ээлтэй, тогтвортой замаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг илүү сонирхох болсон. Хэрэглэгчдийн энэ сонирхолд нийцүүлэн

боловсруулах үйлдвэрүүд мөн худалдан авагчид байгальд ээлтэй, тогтвортой замаар үйлдвэрлэсэн, баталгаатай, эргэн мөшгөх боломжтой түүхий эд бэлтгэлийн системийг нэвтрүүлсэн малчид, хоршоодоос түүхий эд, материалаа авах хандлага нэмэгдсээр байна. Түүхий эдийн байгальд ээлтэй, тогтвортой гэдэг ойлголтод эрүүл бэлчээр, эрүүл мал, малын тавлаг байдал, түүхий эдийн чанар, хариуцлагатай малчин, цэвэр, аюулгүй орчин зэрэг үзүүлэлт ордог байна.

Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо энэ тогтолцоог загвар байдлаар Монгол Улсын 34 сумын бэлчээр ашиглагчдын холбоо, түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршоодтой хамтран хөгжүүлэн ажиллаж байгаа юм.

- ⇒ Хувь хүний нууцад хамаарах хүний овог, нэр, регистрийн дугаар, гэр бүлийн мэдээлэл, гэрийн хаяг зэргийг нийтэлж, түгээх нь хүний эрхийн зөрчил.
- ⇒ Улмаар нийгэмд талцал, үймээн самуун үүсгэж, ялгаварлан гадуурхалтыг дэвэргэх эрсдэлтэй.
- ⇒ Ковид 19-ын үед хүний эрхийг эдийн засаг, нийгмийн, иргэний, улс төрийн эрхийг бүхий л хүрээнд хүндэтгэн үзэх нь нийтийн эрүүл мэндийн төлөө авч буй хариу арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх үндэс мөн.
- ⇒ Ковид 19-тэй холбоотой онц байдлын эрх хэмжээ нь хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчдийн ажил, үйл хэргийг няцаах хүчингүй болгох, эсвэл тэднийг чимээгүй болгоход ашиглагдах ёсгүй.
- ⇒ Ковид 19-тэй холбоотой аливаа мэдээлэл, хариу арга хэмжээ нь хүн бүрт хүрэх ёстой.
- ⇒ Хүмүүс өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх аливаа шийдвэр гаргахад оролцох эрхтэй. Ковид 19-тэй холбоотой мэдээллийг олон нийтэд тарааж, арга хэмжээ авахдаа орхигдож болзошгүй эрсдэлтэй хүмүүст /шашны цөөнх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЛБГТИ зэрэг/ онцгой анхаарал хандуулах.
- ⇒ Ковид 19-ийн тархалтын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний үед эмэгтэйчүүдийн үзэл бодол, дуу хоолой болон тэдний мэдлэг мэдээллийг тусгах нь чухал.

НУБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ГАЗРЫН “КОВИД 19” удирдамжаас



**ҮЗЭН ЯДАЛТ
ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТ
БУС СЭТГЭЛИЙН
ДЭМ ТҮГЭЭ**







“ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ
ГУТААН ДОРМЖЛОХ НЬ
ОЛОН СӨРӨГ НӨЛӨӨТЭЙ ”

- ХАЛДВАРАА НУУХ
- ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ АВАХААС ЗАЙЛСХИЙХ
- ШИНЭ ГОЛОМТ ҮҮСЭХ
- ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

Цахим сонины редакцын хаяг



БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН

Боловсролын хүрээлэн

Улаанбаатар хот 14191
Сүхбаатар дүүрэг 8-р хороо
Энхтайваны өргөн чөлөө-10
Багшийн хөгжлийн ордны 4 давхар

Емайл: info@esd.mn
info@mier.mn
Вэбсайт: www.mier.mn
Утас: +976 70125286
+976 80474838.



Байгаль орчны мэдээлэл
сургалтын төв

Улаанбаатар хот 14210
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Элчингийн гудамж
Шүрэн оффис 5 давхарт 5 тоот

Емайл: info@feemongolia.mn
ceo@feemongolia.mn
Вэбсайт: feemongolia.mn
Утас: +976 88111893
+976 99085775

